


МОНГОЛ УЛС

БАРИЛГЫН ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ

“БИГС”ХХК

Архив № 2019.06.38

ЗТ12-1833/17



**ДОРНОД АЙМГИЙН ХӨЛӨНБУЙР СУМЫН ТӨВД
БАРИГДАХ “100 хүүхдийн дотуур байр”-ны БАРИЛГЫН
ТАЛБАЙН ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ
АЖЛЫН ДҮГНЭЛТ**
/Ажлын зургийн үе шатанд/

БАТЛАВ

ХЯНАСАН

БОЛОВСРУУЛСАН



С.БАТТОГТОХ

А.ГАЛБАДРАХ

С.РЭНЦЭНДОРЖ

Утас:98000981

Улаанбаатар хот 2019 он

ГАРЧИГ

I. ОРШИЛ	3
II. СУДАЛГААНЫ РАЙОНЫ ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	4
II.1. БАЙРШИЛ	4
II.2. УУР АМЬСГАЛ	4
II.3. ГЕОМОРФОЛОГИЙН ХЭВ ШИНЖ	6
II.4. ГЕОЛОГИЙН ТОГТОЦ	6
II.5. ГИДРОГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ	6
II.6. ФИЗИК-ГЕОЛОГИЙН ҮЗЭГДЭЛ, ҮЙЛ ЯВЦ	6
III. ТАЛБАЙН ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ БА ХӨРСНИЙ ФИЗИК-МЕХАНИК ШИНЖ ЧАНАР	7
IV. ДУГНЭЛТ	8
V. АШИГЛАСАН МАТЕРИАЛ	9
VI. ЦООНОГИЙН БИЧИГЛЭЛ	10

ХАВСРАЛТ

- БАРИМТ МАТЕРИАЛЫН ЗУРАГ /М1:1000/
- ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН ЗҮСЭЛТ /I – I' идуунаар/
- ХӨРСНИЙ ФИЗИК ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН НЭГДСЭН ХҮСНЭГТ

I. ОРШИЛ

Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын ЕБСургуулийн захиалгаар Хөлөнбуйр сумын төвд баригдах “100 хүүхдийн дотуур байр”-ны барилгын талбайн инженер-геологийн судалгааны ажлыг Барилгын Инженер-Геологийн Судалгааны “БИГС”ХХКомпани гүйцэтгэв.

Судалгааны хээрийн ажлыг 2019 оны 5-р сарын 20-ны өдөр инженер Л.Батнасан, эксковаторчин Ж.Мөнх-Эрдэнэ, туслах ажилтан Ж.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй бригад эксковатороор гүйцэтгэв.

Төлөвлөж буй барилгын талбайд 4.0 м гүнтэй 3 ширхэг шурф малтаж, хөрсний дээж 6 ширхэгийг авч, малталт-дээжлэлтийн ажлыг гүйцэтгэв.

Талбайд малтсан цооногийг кадастарын зурагт оруулан амсарын өндөрийг зохиомлоор өглөө.

Хээрийн судалгааны материал, маршрутын судалгаа, лабораторийн шинжилгээний үр дүнг харьцуулан нэгтгэж техникийн тайланг инженер С.Рэнцэндорж ажлын зургийн үе шатанд зориулан боловсруулав.

Судалгааны ажилтай холбогдсон эх материалуудыг тайлангийн 1-р хувьд хавсаргаж “БИГС” ХХК-ийн архивт хадгалав.

II. СУДАЛГААНЫ РАЙОНЫ ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

II.1. Байршил

Судалгааны талбай нь Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын төвд одоо байгаа сургууль болон сургуулийн спорт заалны барилгын баруун урд талд барихаар төлөвлөсөн байна. /Тойм зураг үз/



Судалгааны талбайн тойм зураг

II.2. УУР АМЬСГАЛ

Судалгааны районы уур амьсгалын үзүүлэлтүүдийг “Барилгад хэрэглэх уур амьсгал, геофизикийн үзүүлэлт (БНБД 23-01-09)-ийн Хөлөнбуйр, Чойбалсан станцын үзүүлэлтээр өглөө.

Гаднах агаарын сар, жилийн дундаж температур, °C

Станцын нэр	Сар												Жил
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	
Хөлөнбуйр	-20.8	-16.3	-7.4	3.3	11.3	17.4	19.9	16.9	10.8	1.4	-9.8	-17.1	0.8

Гаднах агаарын үнэмлэхүй хамгийн их температур, °C

Станцын нэр	Үнэмлэхүй хамгийн их	Он, сар, өдөр	VII сарын үнэмлэхүй ихийн дундаж
Чойбалсан	41.0	2004.VII.21	34.2

Гаднах агаарын үнэмлэхүй хамгийн бага температур, °C

Станцын нэр	Үнэмлэхүй хамгийн бага	Он, сар, өдөр	I сарын үнэмлэхүй ихийн дундаж
Чойбалсан	-41.6	1951.I.4	-32.7

Агаарын чийгшил, хур тунадасны хэмжээ

Станц	Хоногийн хамгийн дулаан цагийн харьцангуй чийгшил			Хур тунадас				
	Халуун сар	Хүйтэн сар	Жил	Дулаан үе	Хоногийн хамгийн их	Он	Сар	өдөр
Чойбалсан	47	71	242.0	229.5	91.9	1998	VII	06

Барилга, байгууламжийн техник технологийн тооцооны температур, °C

Станц	Гадна агаарын тооцооны температур, °C					
	Хамгийн хүйтэн үеийн				Хамгийн халуун үеийн нэг хоногийн	Барилгын уур амьсгалын бүсийн дугаар
	1 хоног	3 хоног	5 хоног	Агаар сэлгэлтийн		
Хөлөнбуйр	-36.2	-33.4	-30.6	-21.3	29.9	III

Жил, сарын дундаж салхины хурд, м/с

Станц	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	өвөл	Жил
Хөлөнбуйр	4.9	4.5	4.5	5.6	5.2	4.4	3.6	3.5	4.2	4.3	4.6	4.9	4.8	4.5

Салхины тооцооны их хурд м/с

Муж	Газрын түвшнээс дээш өндөр, м			
	Газар /10/	100	200	500
1 жилд 1 удаа тохиолдох салхины хурд				
I	18	26	28	31
5 жилд 1 удаа тохиолдох салхины хурд				
II	21-25 /23/	32	35	40
10 жилд 1 удаа тохиолдох салхины хурд				
III	26-30 /28/	39	43	49
20 жилд 1 удаа тохиолдох салхины хурд				
II	26-30 /28/	39	43	43

II.3. Геоморфологийн хэв шинж

Судалгааны талбай нь Хэрлэн голын татамын дээрх дэнжийн зөөгдөл-хуримтлалын хэв шинжит гадаргууд байрлах ба тэгшивтэр тогтоцтой.

II.4. Геологийн тогтоц

Судалгааны талбайд Дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай элсэн хурдас тархсан.

II.5. Гидрогеологийн нөхцөл

Судалгааны талбайд хөрсний ус илрээгүй.

II.6. Физик-геологийг үзэгдэл, үйл явц

Судалгааны талбайд физик-геологийн үзэгдэл, үйл явц хөгжөөгүй.

Ш. ТАЛБАЙН ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ БА ХӨРСНИЙ ФИЗИК - МЕХАНИК ШИНЖ ЧАНАР

Судалгааны талбайд илэрсэн хөрсний нас, гарал үүсэл, ширхэгийн бүрэлдэхүүн, физик-механик шинж чанараас нь хамааруулж инженер-геологийн 1 элементэд /ИГЭ/ ангилан шинж чанарыг дор үзүүлэв.

Судалгааны талбайд өнгөн хөрс 0.4 метр зузаантай илэрсэнийг шинж чанарыг нь тусгайлан авч үзээгүй болно. /Инженер-геологийн зүсэлт үз/

ИГЭ-1. Жижиг ширхэгтэй элс

Бор шаргал өнгөтэй, чийгтэй жижиг ширхэгтэй элсэн хөрсний ширхэгийн бүрэлдэхүүний дундаж утгыг тодорхойлбол (%):

• Хайрга	3.9
• Элс	80.3
• Тоос	9.8
• Шавар	6.0 тус тус агуулагдана.

Жижиг ширхэгтэй элсэн хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг тодорхойлбол:

• Байгалийн чийг	0.073
• Хувийн жин, г/см ³	2.65
• Эзэлхүүн жин, г/см ³	1.79
• Цогцсын эзэлхүүн жин, г/см ³	1.66
• Сүвшил, %	37.28
• Сүвшлийн итгэлцүүр	0.595
• Чийглэгийн зэрэг	0.32

Жижиг ширхэгтэй элсэн хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утгыг БНБД 50-01-16-өөр өгвөл:

Норматив утга:

• Зууралдлын хүч	$C^H=3$ кПа
• Дотоод үрэлтийн өнцөг	$\varphi^H=32^\circ$
• Хэв гажилтын модуль	$E=31$ МПа

Тооцооны утга:

• Зууралдлын хүч	$C^I=2$ кПа	$C^{II}=3$ кПа
• Дотоод үрэлтийн өнцөг	$\varphi^I=29^\circ$	$\varphi^{II}=32^\circ$
• Тооцооны эсэргүүцэл	$R_0=2.0$ кгс/см ²	

Жижиг ширхэгтэй элс нь овойлтгүй хөрсөнд нормчилогдоно.

Газар шорооны ажлын зэрэг нь гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – I.

IV. ДҮГНЭЛТ

1. Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын төвд баригдах "100 хүүхдийн дотуур байр"-ны барилгын талбай нь инженер-геологийн энгийн нөхцөлтэй талбайд хамаарна.
2. Судалгааны районы Уур амьсгалын үзүүлэлтүүдийг тус судалгааны ажлын II.2-р бүлэгт тусгасан болно.
3. Судалгааны талбайд хөрсний ус илрээгүй.
4. Судалгааны талбайд тархсан буурь хөрсний механик шинж чанарын тооцооны үзүүлэлтийг хүснэгтээр үзүүлэв.

Хөрсний төрөл /ИГЭ-ийн дугаар/	Эзлэхүүн жин	Зууралдлын хүч		Дотоод үрэлтийн өнцөг		Хэв гажилтын модуль
	γ_{zs}	C ^I	C ^{II}	φ^I	φ^{II}	E
	г/см ³	кПа		градус		МПа
Жижиг ширхэгтэй элс /ИГЭ-1/	1.79	2	3	29	32	21

5. Судалгааны талбайд тархсан хөрсний тооцооны эсэргүүцэл, газар шорооны ажлын зэрэг, хөрсний овойлтын зэргийг хүснэгтэд үзүүлэв.

Хөрсний төрөл	Тооцооны эсэргүүцэл R_0 (кгс/см ²)	Газар шорооны ажлын зэрэг	Овойлтын зэрэг
Жижиг ширхэгтэй элс /ИГЭ-1/	2.0	I	Овойлтгүй

6. Судалгааны талбайд тархсан хөрсний улирлын хөлдөлтийн норматив гүнийг дор үзүүлэв.


- Жижиг ширхэгтэй элс /ИГЭ-1/ - 2.8 м

7. Хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл /Ом.м /-ийг хүснэгтээр лавлахаас өглөө.

Хөрсний төрөл	Хувийн цахилгаан эсэргүүцэл /Ом.м/	
	Усгүй	Устай
Жижиг ширхэгтэй элс /ИГЭ-1/	100-5000	40-200

8. Судалгааны талбай нь газар хөдлөлтийн 5 баллын бүсэд хамаарна.

Дүгнэлт бичсэн:  /С.Рэнцэндорж/



V. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох норм ба дүрэм /БНБД 50-01-16/
2. Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлтүүд /БНБД 23-01-09/
3. Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх норм ба дүрэм. /БНБД 22.01.01*/2006.Улаанбаатар хот 2006 он
4. Инженер-геологийн судалгааны тайлан, дүгнэлт бичих дүрэм. /БД 11.107.11/
5. Барилгын инженер-геологийн ажил. /БНБД 11.03.01/
6. Земляные работы. /СНиП IV-5-82/. М., 1982 г.

VI. ЦООНОГИЙН БИЧИГЛЭЛ

Ш-1 /X=646069, Y=5309667/

Гүн -4.0 м

Диаметр 2x2 м

1. Бор саарал бор хүрэн өнгөтэй өнгөн хөрс
2. Бор шаргал өнгөтэй, чийгтэй элс

Хөрсний ус илрээгүй

Зохиомол өндөр 744.0 м

Огноо: 2019.5.20

(0.00-0.40)/0.40

(0.40-4.00)/3.60

Ш-2 /X=646048, Y=5309684/

Гүн -4.0 м

Диаметр 2x2 м

1. Бор саарал бор хүрэн өнгөтэй өнгөн хөрс
2. Бор шаргал өнгөтэй, чийгтэй элс

Хөрсний ус илрээгүй

Зохиомол өндөр 744.0 м

Огноо: 2019.5.20

(0.00-0.40)/0.40

(0.40-4.00)/3.60

Ш-1 /X=646047, Y=5309710/

Гүн -4.0 м

Диаметр 2x2 м

1. Бор саарал бор хүрэн өнгөтэй өнгөн хөрс
2. Бор шаргал өнгөтэй, чийгтэй элс


Хөрсний ус илрээгүй


Зохиомол өндөр 744.0 м

Огноо: 2019.5.20

(0.00-0.40)/0.40

(0.40-4.00)/3.60

Бичиглэл үйлдсэн:  /Л.Батнасан/





ТАНИХ ТЭМДЭГ



"БИГС" ХХК

Гүйцэтгэгч			
Захиалагч	Хөлөнбуйр сумын Ерөнхий боловсролын сургууль		
Объект	Хөлөнбуйр сумын төвд барилдах "100 хүүхдийн дотуур байр"-ны барилгын талбайн инженер-геологийн судалгаа		
Шалгасан	С.Баттогтох	Зургийн нэр	
Зохиосон	А.Галбадрах	Зургийн дугаар 1	
Зурсан	Б.Чанцал	Барилг материалын зураг	
			Масштаб Хэвгээ 1:1000
			Үе шат А3

ТАНИХ ТЭМДЭГ



Шурфын дугаар	● Ш-1	● Ш-2	● Ш-3
Амсарын зохиомол өндөр, м	744.0	744.0	744.0
Хоорондын зай, м	25.6	26.5	

"БИГС" ХХК

Гүйцэтгэгч	Хөленбууір сумын Ерөнхий боловсролын сургууль			Үе шат
Захиалагч	Хөленбууір сумын төвд барилдах "100 хүүхдийн дотуур байр"-ны барилгын талбайн инженер-геологийн судалгаа			A3
Объект	Шалгасан	Зургийн нэр	Зургийн дугаар 2	
Зохиосон	А.Галбадрах	Инженер-геологийн зүсэлт I - Г шудлуунаар		Масштаб Босоо 1:100 Хэвтээ 1:500
Зурсан	Б.Чанцал			

Хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүдийн нэгдсэн хүснэгт

№	Цооногийн дугаар	Дээжлэлт хийгдсэн гүн (м)	Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүн, %												Байгалийн чийг	Урсгалын хязгаар	Имрэглэлийн хязгаар	Уян налархайн тоо	Хувийн жин (г/см ³)	Эзэлхүүн жин (г/см ³)	Цогцсын эзлүүн жин (г/см ³)	Сүвшил (п)	Сүвшлийн илгээлүүр (с)	Чийглэлийн зэрэг (G)	Консистенц (L)	
			сайр, сайрга			элс						тоос														шавар
			>10	10-5	5-2	2-1	1-05	0.5-0.25	0.25-0.1	0.1-0.05	0.05-0.01	0.01-0.005	<0.005													
ИГЭ-1. Жижиг ширхэгтэй элс																										
1	Ш-1	1.2	0.0	2.1	3.2	3.1	6.9	24.6	22.9	21.0	5.6	4.1	6.5	0.056	-	-	2.66	1.79	1.70	36.28	0.569	0.26	-			
2	Ш-1	3.3	0.0	1.2	3.5	1.2	5.5	23.6	21.5	27.1	6.3	3.9	6.2	0.068	-	-	2.66	1.78	1.67	37.34	0.596	0.30	-			
3	Ш-2	2.0	0.0	2.8	2.1	2.3	6.8	25.5	26.5	19.2	4.9	3.6	6.3	0.062	-	-	2.65	1.76	1.66	37.46	0.599	0.27	-			
4	Ш-2	3.6	0.0	1.1	1.6	3.2	8.5	23.1	28.3	18.0	6.2	4.5	5.5	0.082	-	-	2.65	1.78	1.65	37.92	0.611	0.36	-			
5	Ш-3	3.0	0.0	1.3	1.8	1.1	9.2	26.9	23.5	21.6	5.5	3.2	5.9	0.082	-	-	2.65	1.81	1.67	36.87	0.584	0.37	-			
6	Ш-3	3.8	0.0	1.1	1.6	2.6	6.5	22.8	25.4	23.7	6.1	4.6	5.6	0.086	-	-	2.65	1.79	1.65	37.80	0.608	0.37	-			
Хамгийн их			0.0	2.8	3.5	3.2	9.2	26.9	28.3	27.1	6.3	4.6	6.5	0.086	-	-	2.66	1.81	1.70	37.92	0.611	0.37	-			
Хамгийн бага			0.0	1.1	1.6	1.1	5.5	22.8	21.5	18.0	4.9	3.2	5.5	0.056	-	-	2.65	1.76	1.65	36.28	0.569	0.26	-			
Дундаж			0.0	1.6	2.3	2.3	7.2	24.4	24.7	21.8	5.8	4.0	6.0	0.073	-	-	2.65	1.79	1.66	37.28	0.595	0.32	-			
Хэсгийн утга			3.9			80.3						9.8			6.0			0.073	-	-	37.28	0.595	0.32	-		

Боловруулсан инженер:  С.Рэнцэндорж

БАТЛАВ

Дорнод аймгийн ГХБХБГазрын


ДАРГА



/Д. ДАМДИНБАЗАР/

"БИГС" ХХК-ийн

ЗАХИРАЛ



/С.БАТТОГТОХ/

**ИНЖЕНЕР – ХАЙГУУЛЫН СУДАЛГААНЫ
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

Дугаар . . .

20. . . оны . . . -р сарын . . . -ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.

1.1. Энэхүү гэрээг нэг талаас цаашид

. захиалагч гэх), нөгөө талаас "БИГС" ХХК (Улсын бүртгэлийн дугаар 9011419015, Регистрийн дугаар 5720931, цаашид гүйцэтгэгч гэх), нар Монгол Улсын Иргэний хууль, холбогдох бусад хууль, тогтоомжийг удирдлага болгон дараах нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

1.2. Гэрээний зорилго нь: - **Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын баригдах . Ерөнхий Боловсролын Сургуулийн дотуур байрны барилгын**

талбайн инженер-хайгуулын судалгааны ажил гүйцэтгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах, талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлоход оршино.

1.3 Гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн гэрээт ажлыг бүрэн дуусгаж, Захиалагч ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

Хоёр. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ.

2.1. Инженер–хайгуулын судалгааны ажил хийх, техникийн даалгаврыг ажил гүйцэтгэгч талд энэхүү гэрээ байгуулагдаснаас хойш 3 хоногт багтаан гаргаж өгнө.

2.2. Захиалагч нь гүйцэтгэгчийн ажлын явцтай танилцах, шаардлагатай бол нэмэлт мэдээлэл гаргуулах эрхтэй.

2.3. Инженер–геологийн судалгааны ажлын хөлсийг тус гэрээний 4-р зүйлд заасан нөхцлөөр тогтоосон хугацаанд нь төлөх үүрэгтэй.

2.4. Захиалагч судалгааны ажлын тайланг хүлээн авч, зохих ажлын хөлсийг бүрэн төлсөнөөр ажил гүйцэтгэгчийн ажлын үр дүнг өмчлөх эрхтэй болно.

2.5. Ажил гүйцэтгэгчээс гаргаж өгсөн судалгааны материал болон дүгнэлтэд дутагдал илэрсэн тохиолдолд хугацаа тогтоож, ажлыг үнэ төлбөргүй дахин хийлгүүлэх, түүний улмаас өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй.

Гурав. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ.

3.1. Гүйцэтгэгч нь инженер–хайгуулын судалгааны ажлыг захиалагчаас өгсөн техникийн даалгаврын хүрээнд орчин үеийн техник технологийн зохих түвшинд хийж, тогтоосон стандартын дагуу техникийн дүгнэлт гаргаж өгнө.

3.2. Гэрээгээр хүлээсэн судалгааны ажил үүргийг өөрийн эд хөрөнгө, техник, багаж хэрэгслээр гүйцэтгэнэ.

3.3. Захиалагч талд хүлээлгэн өгсөн судалгааны ажлын үнэн зөв болохыг өөрийн хөрөнгөөр хариуцна.

3.5. Захиалагчаас өгсөн техникийн даалгавар, ажлын төрөл, хэмжээг тодруулах, тэр хүрээнд нэмэлт мэдээлэл гаргуулах эрхтэй.

3.6. Судалгааны тайлан дүгнэлтэд ойлгомжгүй, алдаа илэрсэн тухай захиалагчаас мэдэгдэснээс хойш ажлын 3 хоногт багтаан дутагдалыг өөрийн зардлаар арилгана.

Дөрөв. ТӨЛБӨР ТООЦОО.

4.1. Инженер-геологийн судалгааны ажлын үнийг 3'190'000/гурван сая нэг зуун ерэн мянган/ төгрөгөөр харилцан тохиролцов. Үнэнд НӨАТ багтсан.

4.2. Захиалагч нь энэхүү гэрээг байгуулсанаас хойш 3 хоногт багтаан ажил гүйцэтгэгчид ажлын хөлсний нийт үнийн дүнгийн 50 хувийг урьдчилан төлнө.

4.3. Ажил гүйцэтгэгчээс ажлын үр дүн болох судалгааны тайлан дүгнэлтийг усин экспетрээр баталгаажуулсаны дараа үнийн дүнгийн үлдэгдэл 50 хувийн төлбөрийг төлж барагдуулна.

Тав. ХАРИЛЦАН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ.

5.1. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн хугацаанд захиалсан ажлыг гүйцэтгэж захиалагчид хүлээлгэн өгөөгүй, мөн тогтоосон хугацаанд дутагдлыг арилгаагүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутам ажлын үнийн дүнгийн 0.2 хувиар алданги тооцох болно.

5.2. Захиалагч хүндэрүүлэн үзэх шалтгаангүйгээр тогтоосон хугацаанд судалгааны ажлын үнийг гүйцэтгэгчид шилжүүлээгүй хожимдуулбал хоног тутам үнийн дүнгийн 0.2 хувиар алданги төлнө.

5.3. Энэхүү гэрээтэй холбогдон талууд хооронд үүсэх аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг эрмэлзэх ба шийдвэрлэх боломжгүй бол маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа. БУСАД ЗҮЙЛ.

6.1. Энэхүү гэрээ нь талууд хооронд энд дурдсан асуудлаар тогтсон хэлцэлийг бүрэн илэрхийлж бүхий л нөхцөлийг тодорхойлсон бөгөөд энэ гэрээ хүчин төгөлдөр үйлчилсэн өдрөөс эхлэн тус гэрээний талаар урьд өмнө талууд хооронд байгуулагдсан хэлцэл, хэлэлцээ, амлалт, ойлголтууд хүчингүйд тооцогдоно.

6.2. Гүйцэтгэгч, захиалагчаас өгсөн удирдамж, зааврыг хүлээн авах эрхтэй бөгөөд уг удирдамж зааврыг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй болно.

6.3. Тус гэрээнд тусгагдаагүй аливаа асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

6.4. Гэрээг 20. . . оны . . . сарын . . . -ны өдөр Улаанбаатар хотод 2 хувь үйлдэж гарын үсэг зурав.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН :

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Дорнод аймгийн
Ерөнхий архитектор

...../Г. ЦОГГЭРЭЛ/

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"БИГС" ХХК-ийн

инженер:

...../Б. БАТЗУЛ/